



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/77

Сүхбаатар сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/80 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан ажил төсөл арга хэмжээнээс эрх шилжүүлэн хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрх шилжүүлэх хөрөнгө оруулалт, ажил, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоолд нийцүүлэн зохион байгуулахыг холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагаанд хяналт тавин мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны албаны дарга /С.Хүрэлбаатар/-т, ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллахыг Хөгжлийн бодлогын хэлтсийн Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонбаасан/-д, гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /М.Нарантуяа/-д, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн албаны дарга /П.Эрдэнэсайхан/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.БҮРЭНБАТ

Аймгийн Засаг даргын 2016 оны
 03 -р сарын 30 -ний өдрийн
 А/77 тоот захирамжийн хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМАГТ 2016 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАХИАЛАГЧИЙН
 ЭРХИЙГ СУМД, БАГУУЛЛАГУУДАД ШИЛЖҮҮЛСЭН ХУВААРЬ**

Д/д	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадар, байршил	Төсөвт өртөг /мянган төгрөг/	2016 онд санхүүжих дүн /мянган төгрөг/	Эрх хүлээн авах сумд, хэлтэс, агентлагийн даргын нэрс
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт				
1.1.30	Жавхлант сумын Хүйтний голд гүүр барих	20,000.0	20,000.0	Жавхлант сумын Засаг дарга С.Нямсүрэн
1.1.42	Жавхлант сумын 2 багт мал эмнэлэг, үржлийн албанд үйлчилгээний хашаа, ванн барих	30,000.0	30,000.0	
1.1.32	Зүүнбүрэн суманд Хүүхэд залуучуудын спорт тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн барих	70,000.0	50,000.0	Зүүнбүрэн сумын Засаг дарга Б.Батчулуун
1.1.33	Хүдэр суманд Орон нутаг судлах танхим, тоног төхөөрөмж	50,000.0	50,000.0	Хүдэр сумын Засаг дарга Б.Наранцэцэг
1.1.34	Баянгол сумын хүүхэд хөгжлийн төвийн барилга гүйцээх	80,000.0	80,000.0	Баянгол сумын Засаг дарга Б.Энхбат
1.1.36	Баруунбүрэн сумын "Бүрэнхан" цогцолбор гүйцээх	80,000.0	80,000.0	Баруунбүрэн сумын Засаг дарга Ж.Наранцэцэг
1.1.40	Цагааннуур суманд 1.2 км хатуу хучилттай зам тавих	480,000.0	100,000.0	Цагааннуур сумын Засаг дарга Ч.Жаргалсайхан
1.3.6	Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын засвар	8,000.0	8,000.0	
	ДҮН	818,000.0	418,000.0	